



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/141

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1 дэх заалтыг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөр батлах тухай 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд Монголын лектор төвийн сургагч багш, Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн сургуулийн багш, хуульч Ү.Амарбат Хэнтий нутгийн залуучуудад зориулсан "Хөгжлийн давалгаа" лекцийг 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Чингис хотод зохион байгуулахад 250000 /хоёр зуун тавин мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Тус арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн зардлаас гаргаж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 682

Аймгийн Засаг даргын 2017 оны
..... дугаар сарын.....өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Ажлын хөлс	250000
	Дүн	250000

2017 оны 12 сарын 29